



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 169

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус үндэслэн “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2020 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 1,590,524,285.03 (нэг тэрбум таван зуун ерэн сая таван зуун хорин дөрвөн мянган хоёр зуун наян таван төгрөг гурван мөнгө) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал (Ү.Төмөрхуяг)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлж, дотоод хяналтыг сайжруулан, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

1.1. Засгийн газрын 2018 оны “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” 8 дугаар тогтоолын 2.2 дахь хэсэгт “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэхийг таслан зогсоох, зөрчсөн албан тушаалтанд хуулийн хүрээнд арга хэмжээ авч байх” гэж заасныг зөрчин “Эрчим хүчний хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт шилжүүлсэн 37,207,300.00 (гучин долоон сая хоёр зуун долоон мянга гурван зуун) төгрөгийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан Улсын төсвийн 1009 0000 8052 дугаар дансанд төвлөрүүлэх;

1.2. Төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалттай холбоотой гэрээ хэлцлийг төрийн өмчийн холбогдох хууль тогтоомж, журам, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 3.17 дахь хэсэгт “Төрийн өөрийн өмчийг бусдад түрээслүүлэхэд холбогдох хууль тогтоомж, захиргааны актыг мөрдөн ажиллах бөгөөд түрээсийн төлбөрийг тогтоосон хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дансанд төвлөрүүлэх” гэж заасны дагуу бусдад ашиглуулах;

1.3. Компанийн өглөгийн дансанд бүртгэлтэй, хөөн хэлэлцэх хугацаа дууссан, барьцаа баталгааны өглөг 523,529,857.24 (таван зуун хорин гурван сая таван зуун хорин есөн мянга найман зуун тавин долоон төгрөг хорин дөрвөн мөнгө) төгрөгийг данснаас хасаж, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бүртгэх асуудлыг Хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлэх;

1.4. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлснээс Улсын төсөвт төвлөрүүлэх хувь хэмжээ тогтоох тухай” 49 дүгээр тогтоолын дагуу “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн “Эмэгтэйчүүдийн зөвлөл” гишүүдэд үйлчлэх төрийн бус байгууллагад үнэ төлбөргүй ашиглуулсан байр талбайн түрээсийн төлбөр

21,840,000.00 (хорин нэгэн сая найман зуун дөчин мянган) төгрөгийг тус төрийн бус байгууллагаас нэхэмжлэн авч 2023 оны 2 дугаар улиралд багтаан Улсын төсвийн 1009 0000 0703 дугаар дансанд төвлөрүүлэх;

1.5.Иргэн, хуулийн этгээдэд ахуйн зориулалтаар түрээслүүлж буй төрийн өмчийн байр талбайд засвар, үйлчилгээг тухай бүр хийж төрийн өмчийн хөрөнгийн хадгалалт хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

1.6.Сангийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу батлагдсан маягтын дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг иж бүрэн, үнэн зөвөөр тайлагнаж байх;

1.7.Худалдан авах бараа, ажил, үйлчилгээг компанийн хэрэгцээ шаардлагад үндэслэн тооцоо судалгааны хийсний үндсэн дээр төлөвлөх, төсөвт өртгийг бодитой тогтоох, шууд худалдан авалт хийхээс зайлсхийх, техникийн тодорхойлолтод тусгагдсан барааны нэр төрөл, тоо хэмжээнд өөрчлөлт оруулахгүй байх.

2.Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалд хяналт тавьж ажиллах үүргээ хангалтгүй биелүүлсэн албан тушаалтан нарт хариуцлага тооцох.

3.Тогтоолын биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 05 дугаар сарын 02-ний өдрийн
169 дугаар тогтоолын хавсралт

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанид
хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах
арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн /сая. төг/	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээ хийсэн. /Тушаал, шийдвэргүй/	120.54	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээ хийхийг таслан зогсоох.
2	Дээд шатны байгууллагад олгосон санхүүгийн дэмжлэг	37.21	Төсвийн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын 2018 оны 8 дугаар тогтоол, 2021 оны 43 дугаар тогтоол, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг мөрдөж ажиллах.
3	Шүүхийн шийдвэрийн дагуу буцаан төлөгдөж буй өндөр настны тэтгэвэрээс суутгагдсан хувь хүний орлогын албан татвар	237.29	
4	Хувь хүний орлогын албан татвар дутуу суутгасан төлбөр	5.44	Хувь хүний орлогын албан татварын хуулийг мөрдөж ажиллах.
5	Хөөн хэлэлцэх хугацаа дууссан өглөг	523.53	Иргэний хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах.
6	Нэмэлт гэрээ байгуулахдаа анхны гэрээний үнийн дүнгээс 20 хувиар хэтэрсэн	49.81	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.3 дахь хэсэгт заасныг мөрдөж ажиллах.
7	Төсөвт өртгөөс хэтрүүлэн худалдан авалт хийсэн.	594.86	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4 дахь хэсэгт заасныг мөрдөж ажиллах.
8	Төрийн өмчийн эд хөрөнгийг төрийн бус байгууллагад сонгон шалгаруулалтгүй, үнэ төлбөргүй ашиглуулсан /Улсын төсөвт төвлөрүүлэх/	21.84	Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах.
Нийт дүн		1,590,524,285.03 (Нэг тэрбум таван зуун ерэн сая таван зуун хорин дөрвөн мянга хоёр зуун наян таван төгрөг гурван мөнгө)	